



БАЯНХОНГОР АЙМАГ  
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/117

Баянсайр

Түүх соёлын үл хөдлөх дурсгалын  
улсын үзлэг тооллогыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 13-ний өдрийн А/581 дүгээр захирамжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Сумын нутаг дэвсгэр дээрх түүх соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын ажлыг хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Соёл-Эрдэнэ (Соёлын төвийн эрхлэгч)

Гишүүд:

Б.Отгонжаргал

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Э.Бат-Эрдэнэ

(Байгаль орчны улсын хяналтын байцаагч)

Н.Ариунжаргал (Бүжгийн багш)

Э.Балжинням (Хэсгийн цагдаа)

Нарийн бичгийн дарга: Г.Норжинба (Номын санч)

2. Сумын нутаг дэвсгэр дээрх хамгаалалтад байгаа Түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг тооллогод бүрэн хамруулах ажлыг 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс 10 дугаар сарын 25-ны хүртэлх хугацаанд чанартай зохион байгуулж, дүнг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний дотор холбогдох газарт хүргүүлэн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Соёл-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Бямбаням)-д даалгасугай.

ДАРГА

С.ЭНХТӨР



642201013

tushaal\Захирамж-2020-01.docx